



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2015 оны 11 дүгээр
сарын 5-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

1. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд Замын-Үүд, Эрээний боомтыг түшиглэн хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай:

- | | |
|-----------|---|
| Дарга | -Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Дэд дарга | -Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын захирал |
| Гишүүд: | -Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Мэдээлэл, дүн шинжилгээний албаны дарга (зөвшилцсөнөөр); |
| | -Дорноговь аймгийн Засаг дарга; |
| | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын аж үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан Засгийн газрын референт; |
| | -Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга; |
| | -Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга; |
| | -Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; |
| | -Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; |
| | -Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын дарга; |
| | -Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга; |
| | -Хил хамгаалах ерөнхий газрын дарга; |
| | -Гаалийн ерөнхий газрын дарга; |
| | -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга; |
| | -Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг дарга; |


-“Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч.

Нарийн бичгийн дарга • -Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын Чөлөөт бүсийн хөгжил, аж үйлдвэрийн паркийн хэлтсийн дарга.

2. Ажлын хэсгийн баримтлах удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Удирдамжийн дагуу Монгол, Хятадын хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судлан санал, дүгнэлтээ 2015 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 12 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Аж үйлдвэрийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Д.ЭРДЭНЭБАТ

МОНГОЛ УЛС, БНХАУ ХООРОНД ХИЛ ДАМНАСАН ЧӨЛӨӨТ
БҮС БАЙГУУЛАХ АСУУДЛЫГ СУДАЛЖ, САНАЛ,
ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Ажлын хэсэг нь Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Эдийн засгийн хөгжлийн яам (хуучин нэрээр), БНХАУ-ын Худалдааны яам хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр ажиллана:

-БНХАУ-ын Ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, хил дамнасан чөлөөт бүсийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

-БНХАУ-ын Худалдааны яамнаас Монгол Улсын Аж үйлдвэрийн яаманд ирүүлсэн Замын-Үүд-Эрээний боомтыг түшиглэн байгуулах Монгол-Хятадын хил дамнасан чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг судалж, дүгнэлт гаргах;

-Хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлаар эрсдэлийн үнэлгээ, менежментийн судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах;

-“Замын-Үүд” чөлөөт бүсийн хилийн цэсийг улсын хилийн шугам хүртэл өргөтгөх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах, газар дээр нь очиж хэмжилт, судалгаа хийх;

-Хил дамнасан чөлөөт бүсийн хил, гаалийн асуудлаар нэгдсэн ойлголтод хүрэх;

-Хил дамнасан чөлөөт бүсийн менежмент, хөрөнгө оруулалт татах асуудлыг судалж, нэгдсэн ойлголтод хүрэх;

-Хил дамнасан чөлөөт бүсийн хууль, эрх зүй, татварын орчны талаар судалгаа хийх, санал боловсруулах;

-БНХАУ-Лаос улсын хилийн хамтын ажиллагааны бүсийн туршлагаас судлах;

-Хил дамнасан чөлөөт бүс дэх нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах асуудлыг судалж, санал боловсруулах.